



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/40

Улаанбаатар хот

Сувилахуйн судалгааны ажлын
тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.7, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 45 дугаар тогтоолын 3.1.22, 3.2.19 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сувилахуйн судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Сувилахуйн судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хийгдэх судалгааны ажлын тоог жил бүр төлөвлөгөөтэйгээр нэмэгдүүлэх, нотолгоонд сууриссан сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, удирдлагад үүрэг болгосугай.

3. Сувилахуйн судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан технологийн бодлогын нэгдсэн баримт бичигт тусгах, салбарт судалгааны ажлын сэдэв зарлах, судалгааны ажил гүйцэтгүүлэхдээ баримтлах, холбогдох сургалт, шинжлэх ухааны байгууллагуудад хүргүүлж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/, Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Ерөнхий мэргэжилтэн /Н.Наранбаатар/-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ





Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 26-ны өдрийн
А/4 дугаар тушаалын хавсралт

СУВИЛАХҮЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

№	Тодорхойлолт/ дэд сэдэв	Тулгамдсан асуудал буюу үлгэрчилсэн сэдэв, хүрээ
---	-------------------------	--

Тэргүүлэх чиглэл 1. Сувилахуйн эмнэлзүйн төрөлжсөн судалгаа

1.1	Нотолгоонд суурисан сувилахуйн тусlamж үйлчилгээг төрөлжсөн мэргэжлийн чиглэл бүрээр хөгжүүлэх	Сувилахуйн 5 шатлалыг төрөлжсөн мэргэжлийн сувилахуйн эмнэлзүйн тусlamж үйлчилгээнд нэвтрүүлэх
		Хүний биеийн эрхтэн системүүдийн өвчлөл, өөрчлөлтийн үед хийгдэх сувилахуйн тусlamж, үйлчилгээний үр дүнтэй загвар
		Сувилгааны онош тавих арга барилыг хөгжүүлэх
		Сувилгааны түүх хөтлөлтийн ур чадварыг сайжруулах
1.2	Олон улсад хийгдсэн судалгааны үр дүнг судлах, нутагшуулах	Сувилахуйн тусlamж, үйлчилгээний гардан үйлдэл, мэргэшсэн тусlamж үйлчилгээ, ур чадвар сайжруулах, энэ чиглэлээр олон улсад хийгдсэн судалгааны үр дүнг судлах, нутагшуулах, ашиглах асуудалд

Тэргүүлэх чиглэл 2. Сувилахуйн тусlamж, үйлчилгээний эрх зүйн орчны шинэчлэл

2.1	Төрөлжсөн мэргэжлийн сувилахуйн тусlamж, үйлчилгээний чанар сайжруулалт	Зонхилон тохиолдох өвчинүүдийн үед үзүүлэх сувилахуйн тусlamж, үйлчилгээний стандарт, заавар
		Халдварт, хавдар, гэмтэл, сэтгэц, арьсны өвчин судлалын сувилахуйн тусlamж, үйлчилгээний заавар, гардан үйлдэл, технологийн хөгжил
		Хүүхэд, эхийн сувилахуйн нотолгоонд сууриссан тусlamж, үйлчилгээ
2.2	Сувилахуйн дагнасан тусlamж, үйлчилгээтэй төвийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг хөгжүүлэх	Сувилахуйн дагнасан тусlamж, үйлчилгээтэй төвийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг хөгжүүлэх
		Хөнгөвчлөх сувилахуйн тусlamж, үйлчилгээний заавар, технологи хөгжүүлэх

Тэргүүлэх чиглэл 3. Сувилахуйн боловсрол судлал

3.1	Сувилахуйн шинжлэх ухааныг хөгжүүлэх	Олон улсын сувилахуйн шинжлэх ухааны судлах зүйлийг манай орны сургалтын агуулга, арга зүйтэй харьцуулан судалсан үнэлгээ
		Сувилахуйн боловсролын тулгамдсан асуудал, өнөөгийн байдалд хийсэн үнэлгээ
		Сувилахуйн боловсрол, тусlamж үйлчилгээний хосолмол байдал
3.2	Сувилахуйн боловсролыг тэргүүлэх байдлаар хөгжүүлэх	Сувилахуйн боловсролын тэргүүлэх чиг хандлага
		Сувилахуйн боловсролын нотолгоонд суурилсан агуулга, арга зүйн шинэчлэл
		Нийгмийн эрэлтэд суурилсан боловсролын агуулга, арга зүйн шинэчлэл
3.3	Сувилахуйн боловсролын хариуцлагатай тогтолцоог бий болгох	Сувилагч мэргэжилтний боловсролын дэвших чиг хандлага
		Мэргэжлийн алдааг мэргэжилтнийг бэлтгэсэн боловсролын байгууллагатай хамтран шийдвэрлэдэг олон улсын тогтолцоог нэвтрүүлэх асуудалд
		Сувилахуйн шинжлэх ухааны судалгааны ажлыг мэргэшүүлэх нь /APN/

Тэргүүлэх чиглэл 4. Сувилахуйн удирдлага зохион байгуулалт, сувилагчийн ажлын ачаалал, хэрэгцээ, ажиллах орчин нөхцөл

4.1	Сувилахуйн тусlamж, үйлчилгээ, удирдлагын үр дүнтэй, үр ашигтай загварыг нэвтрүүлэх нь	Эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн албаны үр дүнтэй, үр ашигтай загварыг нэвтрүүлэх асуудалд
		Эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн тулгамдсан асуудал тодорхойлох асуудалд
		Сувилагчийн ажлын үр дүн, үр ашгийг тооцох нь
		Эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн хүний нөөцийн байдалд хийсэн судалгаа
		Сувилагчийн ажиллах нөхцөл, ажлын байрны хангамж
		Сувилагчийг ажлын байранд оновчтой байршуулах, ажиллуулах арга ажиллагаа, хэрэгцээний судалгаа
4.2	Сувилагчдын ажлын байр, ажиллах орчин нөхцөл, ажлын ачаалал, хэрэгцээг судлах асуудалд	Сувилагчийн ажлын ачааллын судалгаа
		Сувилагчийн ээлжийн ажлын цаг хорогдуулах асуудлаар олон улстай харьцуулсан судалгаа
4.3	Сувилагчдын нийгмийн асуудалд	Сувилагчийн цалин хангамж, нийгмийн тулгамдсан асуудал
4.4	Сувилагчийн ёс зүй	Эмнэлгийн ажилтны харилцааны өнөөгийн түвшин, нийтлэг гаргаж буй алдаа
		Сувилагчийн дүр төрх, ёс зүй, харилцаа

Тэргүүлэх чиглэл 5. Нийгмийн эрүүл мэндийн сувилахуй

5.1	НЭМ-ийн сувилахуйн тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх, анхан шатны сувилахуйн тусlamж, үйлчилгээнд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх	Сувилагчийн гэрээр үзүүлэх тусlamжийн төрлүүд, ажилбар, хүrtтээмжийн хэлбэрүүд, тусlamж үйлчилгээний чанар сайжруулах асуудал, загварчлал
		Сургуулийн байгууллагад ажиллах сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх нэгжийн хэрэгцээ, гүйцэтгэх үүргийн загварчлал
		Цэцэрлэгийн байгууллагад ажиллах сувилахуйн нэгжийн хэрэгцээ, гүйцэтгэх үүргийг загварчлал
		Сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх хувийн салбарыг хөгжүүлэх асуудал
		Сувилагчийн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн загварчлал

оооОооо